



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/335/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261628 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ГАНХУЯГ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/764

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,770,637.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу бүрдүүлж, зарцуулж буй сургалтын урамшууллын хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, үр дүнг үнэлж дүгнээгүй 2021-2024 онд 5,293,024.4 мянган төгрөгийг зарцуулсан;
- Улсын төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой ажил гүйлгээний анхан шатны бүртгэл хөтлөлт, холбогдох мэргэжилтнүүдийн тухайн жилийн улсын төсвийн орлогын ногдуулалт, төлөлт, тооцооны үлдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагаанд удирдлагаас тавих хяналт сул, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай уялдаагүй;
- Газрын тосны мэргэжлийн чиглэлээр суралцаж буй оюутнуудад нээлттэй сонгон шалгаруулалтгүй, сургалтын явцад хяналт хэрэгжүүлэлгүйгээр нийт 263,059.7 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.6, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-94.Docx

1525000397

бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төрөөс геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж орд болохуйц хэтийн төлөвтэй газруудыг нээн илрүүлэх, эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодлогын хүрээнд 2023-2024 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгийн тайлан хэлэлцэх 12 удаагийн хуралдаанаар 104 тайлан хэлэлцэж, элс хайрга, алт, нүүрс, жонш зэрэг голлох ашигт малтмалын 89 ордын нөөцийг Улсын нөөцийн нэгдсэн бүртгэлд бүртгэж, хүлээн авсан байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтыг цахимжуулж, тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд сонгон шалгаруулалтыг 100 хувь цахимаар зохион байгуулж, 196490 гектар бүхий 75 талбайг ялгаж, tender.gov.mn цахим системд ирүүлсэн 357 саналыг нээж, журмын шаардлагыг хангасан 109 оролцогчдын техникийн саналыг үнэлж, Кадастрын хэлтсийн даргын шийдвэрээр 117478 гектар бүхий хайгуулын 62 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт улсын төсөвт төвлөрүүлэх болон үйл ажиллагааны орлогыг мөнгөн сууриар бүртгэхээр тусгасан, сургалтын урамшууллын хөрөнгийг хянаж бүртгэх талаар тусгаагүй зэрэг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Улаанбаатар хотын агаарыг бохирдлыг бууруулах, экологийн цэвэр түлшний эх үүсвэр болох чиглэлийн хүрээнд Улаанбаатар хоттой ойр Төв XXXVI талбайд 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Австралийн UGS компанитай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан байна.

Дорнод аймгийн Матад сум дахь Петро Матад компанийн газрын тосны Матад-XX талбайн Цэн тогоруу ордын нэгдүгээр цооногийг 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр олборлолтод шилжүүлж үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд тус ордын гадаргуугийн байгууламжийн угсралтын ажил, шингэн хагалбар болон олборлолтын туршилтын ажлууд хийгдсэнээр хоногт 200 баррель газрын тос олборлохоор төлөвлөж байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,766,307,400.90	32,538,151,642.96
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	522,242,457.17	179,712,640.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	522,242,457.17	179,712,640.00
31210	Төгрөг	522,242,457.17	179,712,640.00
31211	Төрийн сангийн харилцах	522,242,457.17	179,712,640.00
33	АВЛАГА	8,335,525,364.43	8,113,797,365.86
33500	Бусад авлага	8,335,525,364.43	8,113,797,365.86
33510	Байгууллагаас авах авлага	8,334,336,864.43	8,113,797,365.86
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,188,500.00	-
34	УРЬДЧИЛГАА	89,340,422.37	408,396,000.63
34600	Урьдчилж төлсөн зардал	82,969,550.25	406,986,442.51
34710	Урьдчилгаа тооцоо	6,370,872.12	1,409,558.12
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	6,370,872.12	1,409,558.12
35	БАРАА МАТЕРИАЛ	643,808,803.65	660,855,283.19
35400	Хангамжийн материал	643,808,803.65	660,855,283.19
35410	Бичиг хэргийн материал	8,459,400.05	9,134,952.36
35420	Аж ахуйн материал	564,170,978.53	570,822,366.64
35430	Сэлбэг хэрэгсэл	12,994,129.91	28,373,819.91
35440	Түлш,шатах тослох материал	1,641,375.16	1,255,324.28
35470	Бусад хангамжийн материал	56,542,920.00	51,268,820.00
36	НӨӨЦИЙН БАРАА	23,175,390,353.28	23,175,390,353.28
36400	Шатахууны нөөц	23,175,390,353.28	23,175,390,353.28
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,166,895,355.95	5,085,628,456.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,166,895,355.95	5,085,628,456.69
39200	Биет хөрөнгө	4,869,351,478.15	4,775,665,759.57
39201	Барилга,байгууламж,орон сууц	3,042,801,473.59	3,042,801,473.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	445,074,564.45	532,868,543.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,100,118,849.16	2,256,083,697.95
39204	Хуримтлагдсан элэгдэл	1,459,314,467.56	1,391,997,848.21
39205	Машин,тоног төхөөрөмж (компьютер)	6,571,621,522.82	6,656,629,122.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	5,434,774,892.29	5,754,870,072.83
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	956,650,779.81	985,249,779.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	891,997,162.91	907,234,249.25
39214	Бусад үндсэн хөрөнгө	956,438,687.47	956,438,687.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	527,118,747.49	534,566,288.77
39300	Биет бус хөрөнгө	297,543,877.80	309,962,697.12
39301	Програм хангамж	1,528,437,021.05	1,584,137,021.05
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,417,763,383.25	1,461,044,563.93
39303	Бусад биет бус хөрөнгө	186,870,240.00	186,870,240.00

III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	37,933,202,756.85	37,623,780,099.65
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	207,354,373.01	179,812,640.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	207,354,373.01	179,812,640.00
41300	Өглөг	207,354,373.01	179,812,640.00
41360	Бусад өглөг	207,354,373.01	179,812,640.00
41361	Байгууллагад өгөх өглөг	207,354,373.01	179,812,640.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	37,725,848,383.84	37,443,967,459.65
51	Засгийн газрын хувь оролцоо	10,187,812,519.22	10,187,812,519.22
51100	Засгийн газрын оруулсан капитал	10,187,812,519.22	10,187,812,519.22
51200	Хуримтлагдсан үр дүн	25,092,592,480.84	24,810,711,556.65
51210	Өмнөх үеийн үр дүн	25,092,592,480.84	25,092,592,480.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	(281,880,924.19)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,445,443,383.78	2,445,443,383.78
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	37,933,202,756.85	37,623,780,099.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	414,740,651,897.98	334,660,144,064.74
11	ТАТВАРЫН ОРЛОГО	39,930,409,021.24	45,809,851,469.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж,	39,930,409,021.24	45,809,851,469.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	39,930,409,021.24	45,809,851,469.10
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	36,741,262,474.52	41,866,424,599.48
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	3,189,146,546.72	3,943,426,869.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	369,107,760,976.41	281,430,882,899.64
120	Нийтлэг татварын бус орлого	369,107,760,976.41	281,430,882,899.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	64,370,517,527.71	43,584,496,704.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	58,962,656,384.17	38,454,858,340.01
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,011,001,810.32	4,997,497,539.14
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	396,859,333.22	132,140,825.00
120006	Газрын тосны орлого	304,157,630,440.70	237,846,206,195.49
120009	Бусад орлого	579,613,008.00	180,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,702,481,900.33	7,419,409,696.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,644,881,900.00	7,135,094,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,644,881,900.00	7,135,094,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	57,600,000.33	284,314,896.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,600,000.00	31,385,096.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,000,000.33	252,929,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	415,312,255,047.67	334,942,024,988.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,302,530,305.17	5,540,571,718.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,930,519,581.53	8,753,201,261.38
21	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	4,302,530,305.17	5,540,571,718.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,822,252,722.43	4,921,631,594.78
210101	Үндсэн цалин	1,968,542,469.40	2,927,902,148.17
210102	Нэмэгдэл	573,979,142.63	765,064,106.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	627,472,000.00	794,314,500.00
210104	Урамшуулал	434,808,795.58	434,350,840.00
210105	Гэрээт ажлын хөлс	217,450,314.82	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	480,277,582.74	618,940,123.60
210201	Тэтгэврийн даатгал	479,458,082.74	423,455,362.03
210202	Тэтгэмжийн даатгал	539,000.00	49,585,906.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	74,800.00	24,615,335.31
210204	Ажилгүйдлийн даатгал	18,700.00	24,253,536.23
210205	Эрүүл мэндийн даатгал	187,000.00	97,029,983.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,096,491.02	115,780,741.40
210301	Гэрэл, цахилгаан	21,769,733.20	15,475,296.60
210302	Түлш, халаалт	28,113,387.31	29,065,064.73
210303	Цэвэр, бохир ус	5,025,370.51	3,499,330.07
210304	Байрны түрээс	82,188,000.00	67,741,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	214,567,609.90	167,207,364.30
210401	Бичиг хэрэг	49,711,323.29	24,899,613.69
210402	Тээвэр, шатахуун	47,081,916.86	27,661,076.17
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	63,802,266.56	62,529,012.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	202,000.00	198,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,770,103.19	20,092,760.00
210408	Бараа материал акталсны зардал	-	31,826,702.19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	111,105,292.58	3,047,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	66,000.00	-
210604	Урсгал засвар	111,039,292.58	3,047,100.00
2107	Томилолт, зочны зардал	408,083,323.10	73,645,440.00
210701	Гадаад албан томилолт	239,966,579.10	-
210702	Дотоод албан томилолт	168,116,744.00	73,645,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	922,748,317.04	2,245,131,233.73

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	865,933,527.23	2,205,784,359.98
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,141,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	19,365,490.00	9,999,635.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,347,900.00	2,107,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	531,300.00	492,575.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,295,179.81	24,698,063.75
210807	Газрын төлбөр	171,980.00	1,939,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,961,240.00	110,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	834,388,242.72	607,817,663.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,696,369.00	10,881,332.52
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	832,691,873.72	596,936,331.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	408,381,735,466.14	326,188,823,727.55
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	112,563,709.00	200,000,000.00
213101	Засгийн газрын урсгал шилжүүлэг	112,563,709.00	200,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,065,365,754.77	643,778,236.28
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,636,103,396.21	415,753,838.28
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,208,342.56	26,474,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	357,054,016.00	201,549,898.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	405,508,446,183.87	324,587,996,304.35
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,376,748,514.82	2,911,790,644.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	404,131,697,669.05	321,672,495,062.17
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,710,598.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	695,359,818.50	757,049,186.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	452,439,438.42
213404	Хөрөнгийн (Орлогын буцаалт)	695,359,818.50	304,609,748.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(571,603,149.69)	(281,880,924.19)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(571,603,149.69)	(281,880,924.19)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	415,022,279,448.90	334,724,700,924.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	39,930,409,021.24	45,809,851,469.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж,	39,930,409,021.24	45,809,851,469.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	39,930,409,021.24	45,809,851,469.10

118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	36,741,262,474.52	41,866,424,599.48
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	3,189,146,546.72	3,943,426,869.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	365,885,471,353.20	281,495,439,759.20
120	Нийтлэг татварын бус орлого	365,885,471,353.20	281,495,439,759.20
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	61,722,240,912.50	43,649,053,563.71
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,711,239,102.18	38,533,233,967.33
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,011,001,810.32	5,115,819,596.38
120006	Газрын тосны орлого	304,157,630,440.70	237,846,206,195.49
120009	Бусад орлого	5,600,000.00	180,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,206,399,074.46	7,419,409,696.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,156,399,074.13	7,135,094,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,644,881,900.00	7,135,094,800.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	7,600,000.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	3,503,917,174.13	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,000,000.33	284,314,896.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	31,385,096.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	50,000,000.33	252,929,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	414,021,012,201.73	335,067,230,741.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,302,230,305.17	5,540,561,718.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,216,776,735.59	8,523,489,579.66
21	ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	4,302,230,305.17	5,540,561,718.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	3,821,952,722.43	4,921,621,594.78
210101	Үндсэн цалин	1,968,542,469.40	2,927,892,148.17
210102	Нэмэгдэл	573,979,142.63	765,064,106.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	627,472,000.00	794,314,500.00
210104	Урамшуулал	434,808,795.58	434,350,840.00
210105	Гэрээт ажлын хөлс	217,150,314.82	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	480,277,582.74	618,940,123.60
210201	Тэтгэврийн даатгал	329,174,854.64	423,455,362.03
210202	Тэтгэмжийн даатгал	38,680,316.00	49,585,906.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	30,447,052.00	24,615,335.31
210204	Ажилгүйдлийн даатгал	7,428,620.88	24,253,536.23
210205	Эрүүл мэндийн даатгал	74,546,739.22	97,029,983.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,096,491.02	115,780,741.40
210301	Гэрэл, цахилгаан	21,769,733.20	15,475,296.60

210302	Түлш, халаалт	28,113,387.31	29,065,064.73
210303	Цэвэр, бохир ус	5,025,370.51	3,499,330.07
210304	Байрны түрээс	82,188,000.00	67,741,050.00
2104	Хангамж, бараа материалын зардал	202,065,226.91	129,554,948.25
210401	Бичиг хэрэг	39,981,230.00	18,266,000.00
210402	Тээвэр, шатахуун	44,089,000.00	28,537,300.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	63,802,066.56	62,529,012.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	202,000.00	198,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	53,990,930.35	20,024,436.00
2105	Нормативт зардал	1,040,000.00	4,889,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,040,000.00	4,889,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	231,695,336.58	108,897,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	26,917,380.00	70,982,000.00
210602	Тавилга	-	20,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	21,188,890.00	-
210604	Урсгал засвар	183,589,066.58	17,915,600.00
2107	Томилолт, зочны зардал	408,083,323.10	73,645,440.00
210701	Гадаад албан томилолт	239,966,579.10	-
210702	Дотоод албан томилолт	168,116,744.00	73,645,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	924,849,683.81	2,528,044,986.61
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	868,784,334.00	2,475,390,280.86
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,141,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	19,365,490.00	23,032,467.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,347,900.00	2,107,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	531,300.00	492,575.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,295,179.81	24,698,063.75
210807	Газрын төлбөр	171,980.00	1,939,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,211,800.00	385,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,716,369.00	22,115,145.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,716,369.00	22,115,145.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	407,804,235,466.14	326,543,741,161.81
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	112,563,709.00	200,000,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	112,563,709.00	200,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,065,365,754.77	998,695,670.54
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,636,103,396.21	770,424,372.54
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	72,208,342.56	26,474,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	357,054,016.00	201,796,798.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	405,508,446,183.87	324,587,996,304.35

213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,376,748,514.82	2,911,790,644.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	404,131,697,669.05	321,672,495,062.17
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,710,598.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	117,859,818.50	757,049,186.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	452,439,438.42
213404	Хөрөнгийн (Орлогын буцаалт)	117,859,818.50	304,609,748.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,001,267,247.17	(342,529,817.17)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	479,024,790.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	479,024,790.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	479,024,790.00	-
223001	Бусад хөрөнгө	479,024,790.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(479,024,790.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	522,242,457.17	(342,529,817.17)
IX	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.00	522,242,457.17
X	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	522,242,457.17	179,712,640.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан	Дахин үнэлгээ	Хуримтлагдсан ашиг	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,664,195,630.53	38,297,451,533.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(571,603,149.69)	(571,603,149.69)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,092,592,480.84	37,725,848,383.84
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-

Тайлант үеийн үрдүн	-	-	(281,880,924.19)	(281,880,924.19)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	24,810,711,556.65	37,443,967,459.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,295,254,500.00	9,241,580,952.20	2,053,673,547.80	81.8
УРСГАЛ ЗАРДАЛ	11,295,254,500.00	9,241,580,952.20	2,053,673,547.80	81.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,065,264,200.00	8,426,025,179.66	639,239,020.34	92.9
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,369,021,000.00	4,921,621,594.78	447,399,405.22	91.7
Үндсэн цалин	3,071,342,800.00	2,927,892,148.17	143,450,651.83	95.3
Нэмэгдэл	938,989,200.00	765,064,106.61	173,925,093.39	81.5
Унаа хоолны хөнгөлөлт	820,945,700.00	794,314,500.00	26,631,200.00	96.8
Урамшуулал	537,743,300.00	434,350,840.00	103,392,460.00	80.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	671,127,600.0	618,940,123.60	52,187,476.4	92.2
Нийгмийн даатгалын шимтгэл	456,366,800.00	423,455,362.03	32,911,437.97	92.8
Тэтгэмжийн даатгал	53,690,200.00	49,585,906.28	4,104,293.72	92.4
ҮОМШ-ний даатгал	26,845,100.00	24,615,335.31	2,229,764.69	91.7
Ажилгүйдлийн даатгал	26,845,100.00	24,253,536.23	2,591,563.77	90.3
ЭМ-ийн даатгал	107,380,400.00	97,029,983.75	10,350,416.25	90.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	204,301,400.00	115,780,741.40	88,520,658.60	56.7
Гэрэл, цахилгаан	40,884,600.00	15,475,296.60	25,409,303.40	37.9
Түлш, халаалт	70,354,900.00	29,065,064.73	41,289,835.27	41.3
Цэвэр, бохир ус	9,237,300.00	3,499,330.07	5,737,969.93	37.9
Байрны түрээс	83,824,600.00	67,741,050.00	16,083,550.00	80.8
Хангамж, бараа материалын зардал	133,264,100.00	129,554,948.25	3,709,151.75	97.2
Бичиг хэрэг	18,266,000.00	18,266,000.00	-	100.0
Тээвэр, шатахуун	28,537,300.00	28,537,300.00	-	100.0

Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	64,612,200.00	62,529,012.25	2,083,187.75	96.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	198,200.00	198,200.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,650,400.00	20,024,436.00	1,625,964.00	92.5
Нормативт зардал	4,905,000.00	4,889,000.00	16,000.00	99.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,905,000.00	4,889,000.00	16,000.00	99.7
Эд хогшил, урсгал засварын зардал	11,543,500.00	11,433,200.00	110,300.00	99.0
Багаж, техник, хэрэгсэл	10,186,600.00	10,164,100.00	22,500.00	99.8
Урсгал засвар	1,356,900.0	1,269,100.00	87,800.00	93.5
Томилолт, зочны зардал	75,576,700.00	73,645,440.00	1,931,260.00	97.4
Дотоод албан томилолт	75,576,700.00	73,645,440.00	1,931,260.00	97.4
Бараа үйлчилгээний бусад зардал	23,231,700.00	22,115,145.02	1,116,554.98	95.2
Бараа үйлчилгээний бусад зардал	23,231,700.00	22,115,145.02	1,116,554.98	95.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,572,293,200.00	2,528,044,986.61	44,248,213.39	98.3
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,120,000.00	-	1,120,000.00	0.0
Даатгалын үйлчилгээ	31,165,100.00	23,032,467.00	8,132,633.00	73.9
Тээврийн хэрэгслийн татвар	2,107,100.00	2,107,100.00	-	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	521,200.00	492,575.00	28,625.00	94.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,528,500.00	24,698,063.75	2,830,436.25	89.7
Газрын төлбөр	1,939,500.00	1,939,500.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,188,800.00	385,000.00	803,800.00	32.4
Харуул хамгаалалтын зардал	66,754,900.00	61,842,000.00	4,912,900.00	92.6
Зөвлөл хороо комиссын	4,189,500.00	4,172,001.00	17,499.00	99.6

гишүүдийн ажлын хөлс				
Байр ашиглалтын үйлчилгээ	446,985,300.00	446,985,300.00	-	100.0
Лабораторийн итгэмжлэл	1,164,600.00	1,160,000.00	4,600.00	99.6
Мэдээлэл сурталчилгааны зардал	12,327,900.0	9,965,000.00	2,362,900.00	80.8
Төлөөлөгчийн үе-г дэмжих хөрөнгө	1,975,300,800.0	1,951,265,979.86	24,034,820.14	98.8
Бусад урсгал шилжүүлэг	2,229,990,300.0	815,555,772.5	1,414,434,527.46	36.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал /сургалт/	2,184,858,900.0	770,424,372.54	1,414,434,527.46	35.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	26,474,500.0	26,474,500.00	-	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,656,900.00	18,656,900.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,295,254,500.00	11,538,167,396.38	(242,912,896.38)	107.6
Улсын төсвөөс санхүүжих	7,135,094,800.00	6,519,890,600.00	615,204,200.00	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих /сургалт өөрийн орлогоос/	2,184,858,900.00	2,969,912,672.45	(785,053,772.45)	135.9
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих /ТҮАДХ/	1,975,300,800.00	2,048,364,123.93	(73,063,323.93)	103.7
Б. Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл			-	-
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт	-	2,296,586,444.18	(2,296,586,444.18)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		100.0
Төсвийн байгууллага	1	1		100.0
АЖИЛЛАГСАД БҮГД	198	198		100.0
Удирдах ажилтан	19	19		100.0
Гүйцэтгэх ажилтан	154	154		100.0
Үйлчилгээний ажилтан	25	25		100.0
Гэрээт ажилтан	22	22		100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
ОРЛОГЫН ДҮН		284,314,896.00
ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		31,385,096
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		252,929,800.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		284,314,896.00
А.Бараа үйлчилгээний зардал		97,464,400.00
Багаж техник хэрэгсэл		60,817,900.00
Тавилга		20,000,000.00
Урсгал засвар		16,646,500.00
Б.Татаас ба урсгал шилжүүлэг		83,139,898.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		83,139,898.00
Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		3,710,598.00
Мөнгөн хөрөнгийн 2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл		-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар үлдэх өртөггүй боловч үйл ажиллагаандаа ашиглаж буй үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй алдаа¹г залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн бүртгэлд үлдэх өртөггүй, хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ болон ашиглах өртөг, хугацаа зэргийг бодитой тогтоох шаардлагатай 1811 ширхэг 8,963,041.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.	1	-			1	-			1	-	1	-
Дүн	1	-			1	-			1	-	1	-

3.2 Аудитаар нийт 5,770,637.5 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 20,461.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 5,750,176.3 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт ны тоо	Тоо	Дүн
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу тусгай зөвшөөрлийн төлбөрийг 1 гэрээлэгч 6.0 мянган ам.доллороор буюу 20,461.2 мянган төгрөгийг дутуу бүрдүүлж, улсын төсвийн орлого дутуу төвлөрүүлсэн.	1	20,461.2	1	20,461.2								
Улсын төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой ажил гүйлгээний анхан шатны бүртгэл хөтлөлт буюу холбогдох мэргэжилтнүүдийн тухайн жилийн улсын төсвийн орлогын ногдуулалт, төлөлт, тооцооны үлдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагаанд удирдлагаас тавих хяналт сул, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай уялдаагүй байна. Тус зөрчлийг арилгуулахаар өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.	1	0.0			1	0.0						
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу бүрдүүлж, зарцуулж буй сургалтын урамшууллын хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт, хариуцлага сул, үр дүнг үнэлж дүгнээгүй байгаа нь тус хөрөнгийг зориулалт бус, үр дүнгүй зарцуулагдах эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн байна. Аудитаар өмнөх оны аудитын ажлын баримтад үндэслэн үзэхэд 2021-2024 онд төгссөн 58, суралцаж байгаа 4 суралцагч байгаа бөгөөд нийт 1,631.7 мянган ам.доллар буюу 5,293,024.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	5,293,024.4			1	5,293,024.4						
Сургалтын урамшууллын хөрөнгөөс дотоодын урт болон богино хугацааны сургалтад албан хаагчдаа хамруулж, сургалтын төлбөр олгож байгаад дотоод хяналт сул, сургалтын үр дүнг тооцох, бүртгэлд тусгах талаар нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байна. Тайлант дотоодын онд уул уурхай, газрын тос түүнтэй	1	72,114.8			1	72,114.8						

холбогдсон техник технологи, удирдахуйн ухаан, хууль, эрх зүй чиглэлээр сургалтад нийт 72,114.8 мянган төгрөгийг зарцуулжээ.												
Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийг хийж буй 8 хуулийн этгээдтэй байгуулсан Эрлийн ажил гүйцэтгэх гэрээний дагуу авто машин нийлүүлэх заалтын хэрэгжилтийг хангаагүй, Өмч хамгаалах байнгын зөвлөлөөс 2007-2017 онуудад эрлийн гэрээний хүрээнд хүлээн авсан, бүртгэлгүй 7 авто машиныг ашиглалтгүй болсон 4 авто машиныг компаниудад буцаан хүлээлгэн өгөх, ашиглалтад буй 3 авто машиныг бүртгэлд тусгахаар шийдвэрлэсэн ч, хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.	1	0.0			1	0.0						
Газрын тосны мэргэжлийн чиглэлээр ШУТИС-д суралцаж буй 35 оюутанд байнгын хорооны 2023 оны 4 дүгээр тогтоол, МУЗГ-ын 2021 оны 241 дүгээр тогтоолыг үндэслэн, нээлттэй сонгон шалгаруулалтгүйгээр нийт 263,059.7 мянган төгрөгийн төлбөрийг төлсөн байна. Мөн санхүүжилтийг олгохдоо суралцагчдын сургалтын явцад хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг хэрэгжүүлээгүй байна.	1	263,059.7			1	263,059.7						
Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд төлөөлөгчийн дэмжих сангийн хөрөнгөөс худалдан авч буй, 56,343.7 мянган төгрөгийн авто машины сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ, 31,090.2 мянган төгрөгийн урсгал засвар, 19,928.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 14,615.0 мянган төгрөгийн шатахуун зэргийг тусгаж батлуулаагүй байна.	1	121,977.4			1	121,977.4						
Өмнөх оноос дамжин хэрэгжиж буй цайны газар, ариун цэврийн өрөөнүүдийн 124,012.5 мянган төгрөгийн урсгал засварын ажлын гүйцэтгэлд төсөв зохиогчийн хяналт хийлгээгүй, зохиогчийн хяналтад төлөвлөсөн	1	0.0			1	0.0						

зардлыг бусад нэмэлт ажилд зарцуулсан байна.												
газрын тосны бүтээгдэхүүний импорт, үлдэгдэл, үнэ болон борлуулалтын мэдээ, мэдээллийн mpetro.smartsolution.mn системийг 2020 оноос ашиглаж байгаа бөгөөд бүртгэлд тусгаагүй боловч, тайлант онд нэмж 19,300.0 мянган төгрөгийн системийн хөгжүүлэлт хийлгэн, биет бус хөрөнгөөр бүртгэсэн байна.	1	0.0					1	0.0				
АМГТГ, Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг КОЙКА-тай хамтран “Монгол Улсын агаарын чанарыг сайжруулах хүрээнд эрчим хүчний эх үүсвэрийн чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх” төслийн хүрээнд Уул уурхай, газрын тосны төв лабораторид 6.8 тэрбум төгрөгийн их засвар хийж, тоног төхөөрөмж нийлүүлснийг хүлээн авсан боловч бүртгэлд тусгаагүй, бүртгэлд тусгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.	1	0.0					1	0.0				
Дүн	10	5,770,637.5	1	20,461.2	7	5,750,176.3	2	0.0		0.0		

3.3 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

Шилэн дансны цахим хуудаст 34 харилцагчтай холбоотой 1,124,905.6 мянган төгрөгийн таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлээгүй байсан бөгөөд аудитын гүйцэтгэлийн үе шатанд нөхөн байршуулсан.	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гэрээлэгчээс бүрдүүлж буй сургалтын урамшууллын хөрөнгөөр сургах суралцагчдын сонгон шалгаруулалтыг 2020 оноос өнөөг хүртэл хийгээгүй, тус салбарын мэргэжилтэн, боловсон хүчнийг бэлтгэх нөөц боломжийг алдагдуулсан байна.	1	-					1	-
Дүн	2	-	-	-	-	-	2	-